

**Нислэгийн цаг уурын төвийн
2019 оны 05 дугаар сард хийсэн ажлын тайлан**

2019.05.24

Зорилт:

Нислэгт цаг агаарын бүх төрлийн урьдчилсан болон бодит мэдээ мэдээллээр шуурхай үйлчлэх, нислэгийн зөрчил саатлын тоог бууруулах, албан хаагчдын мэргэжил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилт тавин ажилласан. Төвийн 2019 оны 5 дугаар сарын ажлын гүйцэтгэл 100 хувьтай байна.

Мэдээлэл үйлчилгээний талаар:

2019 оны 05 дугаар сарын эхний 24-ний байдлаар “Чингис хаан” ОУНБуудал орчмын богино хугацааны TAF мэдээ 153, Урт хугацааны урьдчилсан мэдээ 90, районы урьдчилсан мэдээ 132, угталтын урьдчилсан мэдээ 120, өндрийн салхины урьдчилсан мэдээ 184, аэродромын урьдчилсан мэдээ 61, SIGMET 30, Тосонцэнгэл нисэх буудал орчмын богино хугацааны TAF 46, хөөрөлтийн урьдчилсан мэдээ 149, Ханбумбат НБ-ын TAF 121, Овоот НБ-ын TAF 22, бусад НБуудал орчмын урьдчилсан мэдээ 20 удаа тус тус гаргаж, олон улсын 504, орон нутгийн 389, онцгой ба тусгай үүргийн 13 нислэгийг 215 чиглэлийн урьдчилсан мэдээ болон цаг агаарын төрөл бүрийн мэдээ мэдээллээр үйлчилсэн байна. Төв орон нутгийн 4171 бодит мэдээ, 1412 урьдчилсан мэдээг хүлээн авч дамжуулсан байна. 5 дугаар сард Европын дунд хугацааны тоон прогнозын зураг, Япон, Солонгосын прогноз зураг, болон өндрийн цаг агаарын зураг /850гПа, 700гПа, 500гПа, 300 гПа, ОТ 1000:500/, газрын цаг агаарын зураг, орчны цаг агаарын бодит зураг, онцгой үзэгдлийн зураг, олон улсын нислэгт зориулж салхи температурын орны зураг, FY-2C болон Himawaricast японы хиймэл дагуулын үүлний зураг тус тус хүлээн авч мэдээ зохиолт болон нислэгийн үйлчилгээний ажилд ашигласан. Дэлхийн бүсийн урьдчилсан мэдээлэх систем /WAFS/-ийн бүтээгдэхүүнүүд хэвийн.

36 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүнг боловсруулж, 7 хоногийн төлөв гаргахад зориулж 168 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүн, стандарт өндрүүдийн салхи температурын орны зургуудыг тус тус урьдчилсан мэдээ зохиолт, нислэгийн үйлчилгээнд ашиглаж байна.

Чингис хаан ОУНБ орчмын урьдчилсан мэдээний таарц, нислэгийн саатал:

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад богино хугацааны урьдчилсан мэдээний таарц 3.77%-иар, урт хугацааны урьдчилсан мэдээний дундаж таарц 5.98%-иар өссөн тус тус үзүүлэлттэй байна.

“Чингис хаан” олон улсын нисэх буудал орчмын цаг агаарын байдлаас шалтгаалсан нислэгийн саатлын судалгаа: 5 дугаар сард нийт 32 саатал гарсан байна. Үүнд: таарсан 26, таараагүй урьдчилсан мэдээ-6.

Нислэгийн саатлыг үзэгдэл элементээр нь үзүүлвэл: Баруун хойдын салхитайгаас 31 нислэгийн гарсан бөгөөд урьдчилсан мэдээ таарсан 25, таараагүй-6, Зүүн өмнөдийн салхитайгаас 1 нислэгийн гарсан. Урьдчилсан мэдээ таарсан.

“Чингис хаан” олон улсын нисэх буудал орчмын цаг агаарын бодит ажиглалтын мэдээ-1356, Уур амьсгалын ажиглалт-240, харьцуулсан ажиглалт-23, аюул-12, агаар-12, сарын дундаж мэдээ-4 удаа зохиосон.

Орон нутагт:

Олон улс болон орон нутгийн агаарын шугамд нислэг үйлдсэн үндсэн буудлын 366, бэлтгэл буудлын 874 нислэгт, нислэгийн чиглэлийн урьдчилсан /НИ-5/ мэдээ 342, угталтын урьдчилсан мэдээ 22, буудал орчмын бодит мэдээ 3540, буудал орчмын урьдчилсан мэдээ 1195, районы урьдчилсан мэдээ 421, аэродромын урьдчилсан мэдээ 354, зурвасын гадаргын байдлын мэдээг 10 дамжуулж үйлчилсэн.

Орон нутагт цаг агаараас шалтгаалсан 10 нислэгийн саатал гарсан бөгөөд Алтай нисэх буудалд салхитайгаас цуцалсан 1, Өлгий нисэх буудалд цас орж алсын барааны харагдац муудсанаас цуцалсан 1, Ханбумбат нисэх буудалд шороон болон цасан шуургатай байснаас хүлээсэн 3, Овоот нисэх буудалд цас орсноос цуцалсан 1, Ховд нисэх буудалд салхитай хүлээсэн 1, Хэнтий аймгийн Батширээт, Хөвсгөл аймгийн Тусгалын район болон замын цаг агаар муугаас 3 нислэг цуцалсан 2, хүлээсэн 1 нислэгүүд саатсан байна.

Бусад ажлын талаар:

- Шилэн дансны нэгдсэн системд 2019 оны 5 дугаар сарын байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, шилжилт хөдөлгөөний мэдээлэл болон төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн тушаал шийдвэрийн мэдээллийг оруулсан.
- 5 дугаар сарын 01-нд ИНЕГ-ын хурлын танхимд МАНПИНГ ажлын хэсгийн “Цаг уурын мэдээллийн солилцоо, хэрэгцээ, үйлчилгээний ажлын баг”-ийн анхдугаар хурлыг Нислэгийн цаг уурын төвөөс зохион байгуулж явуулсан.
- 5 дугаар сарын 03-ны өдөр Дэлхийн банкнаас цаг уурын салбарт хэрэгжүүлэх төслийн судалгааны ажлаар мэргэжилтнүүд ирж ажилласан.
- ДЦУБ болон БНСУ-ын ЦУБ-ын хамтарсан НЦУТ-ийн үйл ажиллагааг сайжруулах төслийн талаар ирүүлсэн зөвлөмж, тайлантай танилцаж, 05 сарын 06-нд санал хүргүүлсэн.
- ОУИНБ-аас ирүүлсэн СС асуулгад ANNEХ-3-ын 78 дугаар өөрчлөлттэй холбоотой нэмэлт асуулгуудад тайлбар оруулж хүргүүлсэн.
- 5 дугаар сарын 10-нд төв, орон нутгийн 28 синоптик инженерүүдээс нислэгт урьдчилсан мэдээгээр үйлчлэх эрхийн шалгалт авсан.
- 5 дугаар сарын 10-нд БОХЗТЛ-ийн инженерүүд цаг уурын автомат станцад баталгаажуулалтын өмнөх шалгалт хэмжилт хийж, салхины мэдрүүрийн холхивчийг шинээр сольж, тохиргоо хийж, баталгаажуулалтын гэрчилгээг 1 жилийн хугацаатай олгосон.

Сургалт дадлага, хурал, семинар:

| Нэр | Албан тушаал | Ямар чиглэлээр сурсан | Хугацаа |
|-----------|---|--|-------------------------|
| Д.Ганбат | Чанарын менежерийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч | Авилгатай тэмцэх газрын олон нийтийн төвд “Авлигын эсрэг” 8 цагийн сургалт | 2019.05.08 |
| Н.Басбиш | Дотоод хяналт хариуцсан ажилтан | Авилгатай тэмцэх газрын олон нийтийн төвд “Авлигын эсрэг” 8 цагийн сургалт | 2019.05.14 |
| А.Баярмаа | Сүлжээ, мэдээлллийн сангийн инженер | Үндэсний мэдээлэл технологийн академид программ хангамж мэдээлэл технологийн 3 сарын сургалт | 2019.03.05-наас эхэлсэн |
| Ш.Аюушжав | Сүлжээ, мэдээлллийн сангийн инженер | Үндэсний мэдээлэл технологийн академид вэб мастер мэдээлэл технологийн 3 сарын сургалт | 2019.03.05-наас эхэлсэн |

Орон нутгийн УЦУОШТ-үүд болон нисэх буудлуудаас

| Нэрс | Албан тушаал | Аймаг | Хугацаа |
|---------------|------------------|-------------------------|------------------|
| Д.Алтанзул | Синоптик инженер | Булган аймгийн УЦУОШТ | 2018.04.09-04.30 |
| Г.Түвшинбаяр | Синоптик инженер | Өмнөговь аймгийн УЦУОШТ | 2018.04.16-05.08 |
| Ц.Лхагвасүрэн | Техникч | Өмнөговь аймгийн УЦУОШТ | 2019.05.16-аас |
| П.Цацралтуяа | Техникч | Ховд аймгийн УЦУОШТ | 2019.05.16-аас |

5 сарын 6-наас 10-ны хооронд ЦУОШГ-т болсон орон нутгийн синоптик инженерүүдийн давтан сургалтанд синоптик инженерүүд болон ЕТИ шаардлагатай гэсэн хичээлүүдэд суусан.

Дүгнэлт:

Нислэгийн цаг уурын төвийн 2019 оны 5 дугаар сарын шинжилгээ, мэдээлэл үйлчилгээ, тоног төхөөрөмжийн ажиллагаа “Хэвийн” явагдсан.

Нислэгийн цаг уурын төвийн
Дотоод хяналт, чанарын хэсэг